

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төслийн байршил	3
1.3. Төслийн зорилго	7
1.4. Төслийн төлөвлөлт	7
1.5. Төслийн хүчин чадал, ажиллах горим	8
1.6. Дэд бүтэц	8
БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
2.1. Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл.....	9
2.2. Цаг уур, уур амьсгал.....	9
2.3. Усан сүлжээ	10
2.4. Хөрсөн бүрхэвч	10
2.5. Биологийн олон янз байдал	10
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
3.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал	11
3.2. Газрын гадаргад нөлөөлөх байдал.....	11
3.3. Хөрсний чанарт нөлөөлөх байдал	12
3.4. Усны чанарт нөлөөлөх байдал	12
3.5. Ургамал, амтны аймагт нөлөөлөх байдал.....	12
БҮЛЭГ-4. ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
4.1. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	13
4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
4.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	15
4.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	16
4.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17
4.7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	19
4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	20
4.9. Төслийн 2024 оны БОМТ-ний нийт зардал.....	21
ДҮГНЭЛТ.....	22
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт.....	3
Хүснэгт 2. Төсөл хэрэгжих талбайн булангийн цэгүүдийн солбилцол	3
Хүснэгт 3. Агааарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ	11
Хүснэгт 4. Газрын гадаргад нөлөөлөх байдлын үнэлгээ.....	11
Хүснэгт 5. Ургамал, амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ.....	12
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	16
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17
Хүснэгт 10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх УЗБ-ын төлөвлөгөө	19
Хүснэгт 11. БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	20
Хүснэгт 12. Төслийн 2024 оны БОМТ-ний нийт зардал.....	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг	4
Зураг 2. Төслийн байршлын тойм зураг.....	4
Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн харагдах байдал	5
Зураг 4. Төслийн талбай дахь ногоон байгууламж.....	6
Зураг 5. Үндсэн үйл ажиллагаа явуулах 2 га талбайн ерөнхий төлөвлөлт	7
Зураг 6. Төслийн талбай хүртэлх замын трасс.....	8

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төслийн нэр	“Аялал жуулчлалын бааз” төсөл
2	Төслийн байршил	Төв аймгийн Борнуур сумын Нарт баг
3	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“ТИ СИ ЭС ЭЛ ЖИ” ХХК
4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо
5	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн мэдээлэл	Улсын бүртгэлийн дугаар: 9019015117 Регистрийн дугаар: 5060966
6	Газар ашиглах эрхийн гэрчилгээ	Дугаар: 000000622 Олгосон огноо: 2019.07.18
7	Гэрчилгээгээр эзэмшиж буй газрын талбайн хэмжээ	Талбайн хэмжээ: 199.73 га
8	Цахилгаан хангамж:	Төслийн талбайд дэд станц суурилуулсан.
9	Усан хангамж:	Гүний худаг гаргасан.
10	Хүний нөөцийн төлөвлөлт:	15 хүнийг ажлын байраар хангана.

1.2. Төслийн байршил


“Ти Си Эс Эл Жи” ХХК-ийн үйл ажиллагаа явуулж буй “Аялал жуулчлалын бааз” төслийн талбай нь Засаг захиргааны нэгжийн хувьд Төв аймгийн Борнуур сумын Нарт багийн нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойш 112 км, Борнуур сумын төвөөс баруун хойш 15 км зайд оршино.

“Ти Си Эс Эл Жи” ХХК нь Борнуур сумын Засаг даргын 2019 оны 07-р сарын 18-ны өдрийн А/152 тоот шийдвэрээр 4115006254 тоот нэгж талбарын дугаар бүхий 199.73 га газрыг Аялал жуулчлалын баазын зориулалтаар ашиглах 622 дугаар бүхий гэрчилгээг авсан ба уг талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэнд харууллаа.


Хүснэгт 2. Төсөл хэрэгжих талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	106° 04' 12.36”	48° 27' 35.83”
2	106° 05' 11.63”	48° 28' 30.72”
3	106° 05' 50.13”	48° 28' 24.85”
4	106° 05' 06.05”	48° 27' 23.47”

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг



Зураг 2. Төслийн байршлын тойм зураг

Төсөл хэрэгжих нийт 199.73 га талбайгаас 97 га талбай нь ойн сан бүхий газар бөгөөд 2 га талбайд үндсэн Аялал жуулчлалын баазын барилга байгууламжуудыг байгуулж 50 га талбайд ногоон байгууламж бий болгоно.



Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн харагдах байдал



Зураг 4. Төслийн талбай дахь ногоон байгууламж

1.3. Төслийн зорилго

Монгол орны эрс тэс уус амьсгал, байгалийн онцлогт тохирсон, Монгол оронд ирэх гадаадын жуулчдийг хүлээн авах дэлхий жишигт нийцсэн аялал жуулчлалын иж бүрэн цогцолбор бий болгоход төслийн зорилго, ач холбогдол оршино.


Төслийн хүрээнд тусгагдсан зорилтуудаас:

- ✓ Үйл ажиллагаагаа байнгын тасралтгүй явуулан, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх
- ✓ Ажлын байр нэмэгдүүлэн, ажилчидынхаа ур чадварыг сайжруулах
- ✓ Аялал жуулчлалын компаниудтай хамтран ажиллаж жуулчид тогтмол хүлээн авдаг болох
- ✓ Гадаад, дотоодын жуулчин хүлээн авах тухтай орчинг бүрдүүлэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх
- ✓ Цаашид үйл ажиллагааныхаа хүрээг өргөтгөх хэтийн бодлого боловсруулан ажиллах

1.4. Төслийн төлөвлөлт

“Аялал жуулчлалын бааз” нь нэг ээлжиндээ 60-80 амрагч, аялагчдыг хүлээн авах хүчин чадал бүхий зочид буудал, зуны байшин 10, 5 ханатай гэр буудал 10, спорт цогцолбор, гүний худаг, граж, авто машины зогсоол, спорт тоглоомын талбай, ажилчдын байр, харуул хамгаалалтын байр, зоорь, ариун цэврийн байгууламжаас бүрдэнэ.

Тус жуулчны бааз нь үйл ажиллагаандаа халуун хүйтэн усны шүршүүр, гар нүүр угаах тосгуур, боловсон жорлон, гал тогооны угаалтуур, угаалгын машин, хөргөгч, хөлдөөгч, шарах шүүгээ, хийн плитка, микродолгионы халаагч зэрэг тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна.



Зураг 5. Үндсэн үйл ажиллагаа явуулах 2 га талбайн ерөнхий төлөвлөлт

1.5. Төслийн хүчин чадал, ажиллах горим

Төслийн хүчин чадал: Төсөл нь нэг ээлжиндээ 60-80 хүн хүлээн авах хүчин чадалтай.

Ажиллах горим: “Аялал жуулчлалын бааз” нь 6-10 сарын хооронд үйл ажиллагаагаа явуулна. Нийт 15 хүн ажиллана.

1.6. Дэд бүтэц

Цахилгаан хангамж: Төслийн талбайд дэд станц суурилуулсан.

Зам харилцаа: Улаанбаатар - Дархан-Уул чиглэлийн босоо тэнхлэгийн авто замтай 7.23 км сайжруулсан шороон замаар холбогдсон.



Зураг 6. Төслийн талбай хүртэлх замын трасс

Усан хангамж: Төслийн талбайд байрлах 2.8 л/с ундаргатай өөрийн эзэмшлийн гүний худагас хангана.

БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл

Тус жуулчны баазын байгуулагдах газар нь 1582.2 тоот өндөрлөг бүхий нилээд хэсэгчлэгдсэн дундаж өндөр уулын ар бэлийн тэгшивтэр гадаргад байрлах бөгөөд түүний ойр орчмын нутаг нь физик газарзүйн мужлалаар Сэлэнгийн савын бэсрэг уулын мужийн ойн болон гатмын нуга бүхий Туул Орхоны бүсэд хамрагдана.

Тус баазыг тал бүрээс нь хүрээлэн орших Эрдэнэ (1684.9 м), Ар толгой (1716.8 м) болон Шаварт, Шивэртийн голын усны хагалбар уулс болох 1583.2, 1608.8, 1575.7 тоот өндөрлөгүүд бүхий уулс нь нийт Сэлэнгийн савын бэсрэг уулсын нэгэн адил бөмбөгөр, хавтгайдуу орой хяртай, налуувтар хажуутай, нилээд хэсэгчлэгдсэн дундаж өндөр уулс юм.

2.2. ЦАГ УУР, УУР АМЬСГАЛ

Уулын бэл хажуугаар нарны нийлбэр цацрагийн хэмжээ 1250-1350 квт цаг/м² байдаг. Газар нутгийн нийт чийгшил 200 мм, ууршилт 200-250 мм юм. Уулархаг хэсгээрээ жилд нар гийгүүлэх хугацаа нь 2900-3000 цаг, бэл хормой тал газраараа 2500-2700 цаг байна. Цочирол хүйтрэл хавар V сарын 21-ээс VI сарын 1-ний хооронд намар IX сарын 1-нээс IX сарын 21-ний хооронд дуусна. Цасан шуургатай өдрийн тоо 5-10, бороотой өдрийн тоо 15-25 өдөр үргэлжилдэг.

Агаарын температур: Агаарын температурын жилийн дундаж -1°C - 3°C уулархаг газраа -6°C -аас хүйтэн байна. I сарын дундаж температур -20°C , VII сарынх 17°C орчим байна. Их хүйтрэх өдөр сүүлийн зургаан жилийн байдлаар -25°C бууж хүйтрэх өдөр 40-50, халуун өдөр $+30^{\circ}\text{C}$ -аас давж халах өдөр 10-20, хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа дунджаар 90-100 хоног буюу V сарын 27-наас IX сарын 4-нд байдаг. Ихэнх нь дулааны улиралд ноогдоно.

Агаарын даралт, салхи, шуурганы горим: Борнуур сумын нутаг бүхэлдээ 844-846 гПа даралтын бүсэд оршино. Жилийн дундаж салхины хурд 2.5-4.6 м/с байна.

Агаарын чийг, хур тунадасны онцлог: Хур тунадасны жилийн дундаж хэмжээ 220-360 мм байна. Дулаан улиралд 200-300 мм, хүйтний улиралд 10-20 мм тунадас унадаг. IV сараас X сарын хооронд нийтдээ 305 мм тунадас унадаг бол VII сард нийт тунадасны 31 хувь, X сард 15 хувь нь унадаг.

2.3. Усан сүлжээ

Монгол орны нутагт дэлхийн усны хагалбар оршдог бөгөөд энэхүү усны хагалбарын шугам нь манай орны ус зүйн сүлжээг 29 хэсэгт хуваадаг. Энэхүү төсөл хэрэгжих талбай нь ус зүйн хувьд Хараа голын ай савд багтдаг. Төв аймгийн Борнуур суманд 17 гол горхи, 10 гаруй булаг, 3 нуур бүртгэлтэй байна.

Гүний ус: Хангай-Хэнтийн гидрогеологийн массивт хамаарагдах бөгөөд газар доорхи ус агуулагч чулуулаг нь сэвсгэр мезо-кайнозойн, интрузивын ан цавын болон палеозойн тунамал-хувирмал чулуулгаас тогтоно. Энэ районд дараахь ус үе тархсан байна.

Үүнд:

- ✓ Делювь-пролювийн хурдасны уст үе
- ✓ Протерозой палеозойн хурдасны ан цавын бүс дэх уст комплекс
- ✓ Интрузив гаралтай, ан цавын бүс дэх газар доорхи уст комплекс
- ✓ Мезо-кайнозойн интрузивын ан цавын болон палеозойн тунамал-хувирмал чулуулгаас тогтоно.

2.4. Хөрсөн бүрхэвч

Энэ район нь хөрс газарзүйн мужлалтаар хар хүрэн, цайвар хүрэн хөрстэй Орхон-Сэлэнгийн тойргийн хээрийн бүсэд багтана. Гэрчилгээгээр олгогдсон талбайн ихэнх хэсэг нь өндөрлөг уулын налуугийн шимт үржил шимт хар шороон хөрстэй уулын хормой, баруун, баруун хойд, хойд хэсгээрээ үржил шимээр арвин чанарын үзүүлэлтээр өндөр үнэлгээтэй манай орны хэмжээнд хамгийн сайн хөрстэй хэсэгт тооцогдоно. Энд уулын хар хүрэн карбонатлаг хөрс тархсан байна. Энэ хөрс төслийн талбай орчмын уулархаг хэсгийн урд хажуугаар тархжээ.

Морфологи шинж чанарын хувьд нимгэн давхаргатай, чулуу агуулсан, хөнгөн шавранцар, үе давхаргууд нь бүдэг илэрсэн, хажуугийн нөлөөгөөр дээд давхаргад элэгдэл эвдрэлийн үйл явц байнга явагдаж байдаг онцлогтой. Уулын хажуугийн эгц налуу, хотгор гүдгэрээс хамаарч ялзмагийн үе давхаргын зузаан харилцан адилгүй буюу 10-16 см-т хэлбэлзэнэ.

2.5. Биологийн олон янз байдал

Ой, ургамалжилтын үндсэн бүс бүслүүрийн хувьд авч үзвэл Евроазийн шилмүүст ойн мужийн баруун урд шувтрах үзүүрийн Өвөр байгалийн уулын тайгын провенцийн Хэнтий нурууны баруун үзүүрийн тойрогт багтана. Ойн цоорхой, толгод, модны хаяагаар сөд, таван салаа, тэхийн шээг, тарваган шийр, дэгд, цээнэ, үхэр, хонин улаалзгана, мойл, хад, анис зэрэг жимснүүд хур тунадас сайтай жилд сайн ургадаг. Энэ тойрогт 33.8 мянган га ойн 60 гаруй хувийг нарс, 30 орчим хувийг улиас 10 хувь орчмыг бусад мод болон бутлаг ургамалууд эзэлдэг.

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Хүснэгт 3. Агааарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эрчим цар хүрээ Тохиолдох магадлал	Бага	Дунд	Их
1	Тоосжилт ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх	Зайлшгүй			
		Боломжтой	х		
		Магадлал муу			
2	Тоосжилт ургамалд нөлөөлөх	Зайлшгүй			
		Боломжтой	х		
		Магадлал муу			
3	Тээврийн хэрэгслийн утаа бүс нутгийн агааарын чанарт сөргөөр нөлөөлөх	Зайлшгүй			
		Боломжтой	х		
		Магадлал муу			
4	Ахуйн хог хаягдал тархсанаас эвгүй үнэр гаргах	Зайлшгүй			
		Боломжтой	х		
		Магадлал муу			
Дүгнэлт		Төслөөс орчны агааарын чанарт үзүүлэх 4 боломжит нөлөөллийг тодорхойлсон бөгөөд нөлөөллийн эрчим цар хүрээгээрээ эдгээрийн 4 нь бага зэрэглэлд хамаарч байна. Нийт тодорхойлогдсон нөлөөллүүдээс, боломжтой гэсэн ангилалд 4 нөлөөлөл орж байна. Эндээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас агааарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь харьцангуй бага байхаар байна.			

3.2. ГАЗРЫН ГАДАРГАД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Хүснэгт 4. Газрын гадаргад нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эрчим цар хүрээ Тохиолдох магадлал	Бага	Дунд	Их
1	Геологийн тогтоц өөрчлөгдөх	Зайлшгүй			
		Боломжтой			
		Магадлал муу	х		
2	Газрын гадарга ба хэвлий хог хаягдлаар бохирдох	Зайлшгүй			
		Боломжтой		х	
		Магадлал муу			
3	Олон салаа зам гарч газрын гадаргыг элэгдэл эвдрэлд оруулах	Зайлшгүй			
		Боломжтой		х	
		Магадлал муу			
4	Барилга байгууламжийн нөлөөллөөр газрын гадарга өөрчлөгдөх	Зайлшгүй			
		Боломжтой	х		
		Магадлал муу			
Дүгнэлт	Төслөөс газрын гадарга ба хэвлийд үзүүлэх 4 боломжит нөлөөллийг тодорхойлсон бөгөөд нөлөөллийн эрчим цар хүрээгээрээ эдгээрийн 2 нь дунд 2 бага зэрэглэлд хамаарч байна. Нийт тодорхойлогдсон нөлөөллүүдийн 66% нь боломжтой ба магадлал муутай гэсэн ангилал тус бүр 16.6% байна. Эндээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга ба хэвлийд үзүүлэх нөлөөлөл нь дунд зэрэг байна..				

3.3. Хөрсний чанарт нөлөөлөх байдал

- ✓ Тээврийн хэрэгслийн түлш шатахууны шүүрэл, асгаралтаас хөрс бохирдох
- ✓ Автомашины хөдөлгөөн, олон салаа зам гарснаар хөрсний өнгөн давхарга элэгдэлд орох, нягтрах зэргийн улмаас хөрсний үржил шимт чанар алдагдах
- ✓ Орчны хөрс, ургамал талхлагдах, барилга байгууламж барьснаар хөрсний суулт, эвдрэл, элэгдэл үүсэх
- ✓ Хүнд овор ихтэй материалд тодорхой хэмжээний талбайн өвс ургамал удаан хугацаагаар дарагдсанаас хөрс дагтаршиж ургамал ургах чадвараа алдах, устгах

3.4. Усны чанарт нөлөөлөх байдал

- ✓ Аялал жуулчлалын баазын үйл ажиллагааны явцад хүн, машин тээврийн хөдөлгөөн ихэссэнээр тэр орчмын хөрс, ургамал дагтаршиж цаашлаад ойролцоох булаг, горхийн эхийг бохирдуулах нөхцөл үүсэж болзошгүй.
- ✓ Аялал жуулчлалын баазад хүмүүс ихээр ирж голын ойролцоо амарснаар голын ойр орчим голын эх хатуу хог хаягдлаар бохирдож болзошгүй.

3.5. Ургамал, амтны аймагт нөлөөлөх байдал

Хүснэгт 5. Ургамал, амтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эрчим цар хүрээ Тохиолдох магадлал	Бага	Дунд	Их
1	Төсөл хэрэгжих газрын ургамлын бүрхэвч устгах	Зайлшгүй		x	
		Боломжтой			
		Магадлал муу			
2	Төсөл хэрэгжих газрын ургамлан бүрхэвч доройтох	Зайлшгүй			
		Боломжтой	x		
		Магадлал муу			
3	Төсөл хэрэгжих газар түүний орчимд үүсэх ургамлан нөмрөгийн талхлагдал	Зайлшгүй			
		Боломжтой	x		
		Магадлал муу			
4	Ургамлын бүлгэмдэлд бохир усны нөлөөлөл	Зайлшгүй			
		Боломжтой	x		
		Магадлал муу			
5	Ойн сан бүхий газрын мод, бутыг огтлох, хугалж гэмтээх	Зайлшгүй			
		Боломжтой	x		
		Магадлал муу			
6	Ойн дагалдах баялаг хомсдох	Зайлшгүй			
		Боломжтой	x		
		Магадлал муу			
7	Ойт хээрийн түймэр гарч ой шатах	Зайлшгүй			
		Боломжтой		x	
		Магадлал муу			
Дүгнэлт		Төслөөс ургамлан бүрхэвч болон ойн сан бүхий газар үзүүлэх 6 боломжит нөлөөллийг тодорхойлсон бөгөөд нөлөөллийн эрчимийн цар хүрээгээрээ эдгээрийн 4 нь бага 2 нь дунд зэрэглэлд хамаарч байна. Нийт тодорхойлогдсон нөлөөллүүдийн 100% боломжтой ангилалд багтаж байна.			

БҮЛЭГ-4. ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

“Ти Си Эс Эл Жи” ХХК-ийн “Аялал жуулчлалын бааз” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс төслийн үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн болон БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан зэргийг үндэс болгон боловсруулсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалаллын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

**Төв аймгийн борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой үүсэх хорт хийн нөлөөлөл	Төслийн талбай орчмын ба дотоодын тээврийн замыг тэмдэгжүүлэх, анхааруулах самбар байрлуулах	Төслийн талбай	ш	2	70000	140.0	-
Жуулчин хүлээн авах, байрлуулах үйл ажиллагаанаас ундны усны эх үүсвэр бохирдох, багасах, усны нөөц багасах болон агаарын бохирдол үүсэх	Ногоон байгууламжийн хэрэглээнд ашиглахаар хурын ус цуглуулах, нөөцлөх бичил байгууламж суурилуулах.	Төслийн талбайд	ш	1	100000	100.0	“Усны тухай хууль”, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”
	Усыг хэмнэх төхөөрөмжийг үйлчилгээндээ ашиглах	Ариун цэврийн байр, гал тогооны угаалтуурт		1	40000	40.0	
	Усны тоолуурыг баталгаажуулах	Тоолуур	ш	1	-	-	
	Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх	-	м ³	-	2764	Усны тоолуурын заалтаар тооцож төлөх	
	Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх, самбар байгуулах	Худаг	ш	1	150000	150.0	
Биологийн төрөл зүйлийн хомсдлоос сэргийлэх	Шувууны үүр байгуулах	Төслийн талбайд	ш	5	20.0	100.0	-
	Борнуур сумын ЗДТГ-тай хамтран ойн цэвэрлэгээ хийх	Төслийн талбайд	-	-	-	Дотоод зардлаар	
-	Нийт зардал	-	-	-	-	530.0	-

**Төв аймгийн борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн талбайн орчим нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээх	Аялал жуулчлалын баазын орчмын талбайд ургамал талхлагдсан газруудад олон наст ургамлын үр тариалж ургамалжуулах	Хавар 5-6 сард	м ²	100	10000	1000.0	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн шаардлага
	Аялал жуулчлалын баазын орчныг тохижуулах, мод бут /жимс, жимсгэнэ, чацаргана г.м/ тарих	2024 оноос жил бүр 2 га талбайд	ш	5000 ш	5000	ҮАЗ	
	Услалтын хоолой, шүршүүр бэлтгэх	Төслийн талбай	ш	1	100	ҮАЗ	
Орон нутгаас санал болгосон талбайд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарина.	Санал болгосон талбайд		ш	100	-	ҮАЗ	-
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал		-	-	-	-	1000.0	-

4.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн холбогдох хүрээлэнд даруй мэдэгдэх шаардлагатай.

**Төв аймгийн борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам болон үйлдвэрлэлийн хэрэгцээтэй газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь хэтэрхий удаан байдаг учраас байгаль орчинд хамгийн их хор хөнөөлтэй байдаг.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг ялгах, зайлуулах, устгах, цэвэршүүлэх менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах	Төсөл хэрэгжих талбай	-	-	200.0	200.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
		Хогийн цэгийг стандартыг дагуу байгуулах		ш	1	500.0	500.0	
		Бохир усны цооног, бие засах газарт ариутгал халдваргүйжүүлэлтийг эрүүл ахуйн норм, дүрмийн дагуу тогтмол хийх	Хогийн цэг	ш	3	100.0	300.0	
		Өрөө, гэр бүрт хог хаягдлыг ангилан ялгах боломжтой хогийн сав байрлуулах	Гэр, байшин	ш	10	1 ш ≈100.0	1000.0	
		Төсөл хэрэгжих талбайгаас 50 метр зай дах хог хаягдал, мөс цасыг цэвэрлэх		ш	Жилд 2 удаа	-	Дотоод зардлаар	
		“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хэмжээнд	-	-	-	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	
	Нийт		-	-	-	-	2000.0	-

Төв аймгийн борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Аялал жуулчлалын баазын салхины зонхилох чигийн доод хэсэгт нэг цэг сонгох	Жилд 1 удаа 3 улиралд	1	55.0	55.0	MNS 6341:2012 Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга
2	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Гүний худаг	Жилд 1 удаа 3 улиралд	1	49.7	49.7	MNS ISO 6222: 1998 Усны чанар - Амьдрах чадвартай бичил биетний тоог тоолох. Тэжээлт орчны дотор нь буюу гадарга дээр нь ургасан нянгийн бөөгнөрлийг тоолох MNS ISO 9308-2:1998 Усны чанар - Гэдэсний бүлгийн бичил биетэн, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетэн болон таамаглаж буй E. coli-г илрүүлэх ба тоолох. 1-р хэсэг: Ялтаст шүүлтүүрээр шүүх арга MNS 6340:03 MNS 6461-1:1999 Усны чанар - Сульфит задлах агааргүйтэнбичил биетний (clostrida) үр тоолох баилрүүлэх. 1-р хэсэг. Шингэн тэжээлт орчиндбаяжуулах арга. MNS 6546:2015 Ундны усанд ялтаст шүүлтүүрийн аргаар Pseudomonas aeruginosa актерийг илрүүлэх

**Төв аймгийн борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

3	Ундны усны бүрэн шинжилгээ	Гүний худаг	Жилд 1 удаа 3 улиралд	1	49.0	90.0	MNS 0900: 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүйбайдлын үнэлгээ
4	Ундны усан дахь хүнд металлын агууламж	Гүний худаг, бохирын цооног	Жилд 1 удаа 3 улиралд	2	78.0	156.0	MNS ISO 8288:1999 Усны чанар. Зэс, цайр, хар тугалга, кобальт, кадьми тодорхойлох. Атом шингээлтийн спектрометрийн арга
-	Нийт	-	-	-	-	350.7	-

**Төв аймгийн борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4.7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх УЗБ-ын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024-2025 он				
			Сар 1-4	Сар 5-8	Сар 9-12		
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх	Дотоод зардаар			+	Захирал	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	100.0	+			Менежер	-
3	Орон нутгийн засаг захиргаа, багийн иргэдийн саналыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож байх	Дотоод зардлаар	+	+	+	Захирал	БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06- ны өдрийн А-03 тоот журам
4	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх	Дотоод зардлаар	Тухай бүрт нь			Захирал	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад
5	Ажлын байранд эмийн сан бий болгох	300.0	+			Захирал	
6	Гал түймэр эсэргүүцэх ажлын зохион байгуулалт, багаж хэрэгслийн бүрдлийг шинээр бий болгох	250.0	+			Менежер	Гал түймэр эсэргүүцэх ажлын зохион байгуулалт, багаж хэрэгслийн бүрдлийг 2 жил тутамд шинэчилж байна.
7	Газрын чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд 1 удаа хийлгэх	Гэрээний мөнгөн дүнгээр		+		Захирал	Газрын тухай хууль
8	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Дотоод зардлаар		+		Менежер	Усны тухай хууль
Нийт		650.0	-	-	-	-	-

**Төв аймгийн борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 11. БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
Борнуур сумын Засаг даргын тамгын газар	БОМТ хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлэх, тайлагнах	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	10 сард	Дотоод зардлаар	Захирал	Борнуур сум
БОАЖЯ	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа жилийн БОМТ, БОАЖСайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл, дараа жилийн төлөвлөгөө	11 сар	Дотоод зардлаар	Менежер	-

4.9. Төслийн 2024 оны БОМТ-ний нийт зардал

“Ти Си Эс Эл Жи” ХХК-ийн “Аялал жуулчлалын бааз” төслийн 2024 оны БОМТ-г БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

“Ти Си Эс Эл Жи” ХХК нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 4.53 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө

Хүснэгт 12. Төслийн 2024 оны БОМТ-ний нийт зардал

№	Төлөвлөгөөний бүрдэл	Нийт зардал, сая төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт төсөв	0.53
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний нийт төсөв	1.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний нийт төсөв	-
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	2.0
5	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	0.35
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт төсөв	0.65
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний нийт төсөв	ҮАЗ
-	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	4.53

ДҮГНЭЛТ

Төв аймгийн Борнуур сумын нутагт орших “Ти Си Эс Эл Жи” ХХК-ний хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын бааз” төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Төслийн үйл ажиллагааны явцад нөлөөлөлд гол өртөгч нь хөрс, ургамал, агаар юм. Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллах шаардлагатай.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 4.53 сая төгрөг зарцуулахаар гарсан байна.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Төв аймгийн Борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлан, 2021 он
2. Төв аймгийн Борнуур сумын нутагт орших “Аялал жуулчлалын бааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалын хавсралт, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах” журам